

**ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД ХОТОД БАРИГДАХ 20 ГКАЛ/Ц ХҮЧИН ЧАДАЛТАЙ
ДУЛААНЫ СТАНЦ БАРЬЖ АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ТӨСЛИЙН ҮЕ ШАТНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төв аймгийн төв Зуунмод хотод баригдах 30 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц барьж ашиглах төслийг “Энерго Сервис Монтаж” ХХК компани гүйцэтгэж байна.

Төв аймгийн дулаан хангамжийг сайжруулах төслийн ажлын гүйцэтгэгч “Энерго Сервис Монтаж” ХХК нь төслийн талбайд 2023.04-н сард эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд доорх ажлуудыг гүйцэтгээд байна.

2023 онд төслийн гүйцэтгэл Барилга угсралт 23.5 % Зураг төсөв 70 %

Тоног төхөөрөмж ханган нийлүүлэлт 75 % Нийт гүйцэтгэл 41 % тай явж байна.

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд “Энерго Сервис Монтаж” ХХК-ийн зүгээс доорх үндсэн чиглэлийг голлон хэрэгжүүлэн ажиллалаа.

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

2018 онд батлагдсан 10 аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төслийн техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан байгаль орчны бүрдэл хэсгүүд бүрт тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, үндэслэл, баримтлан ажиллах дүрэм, стандартууд, зардлын хамт оруулсныг мөрдөж ажилласан.

НЭГ. ГАЗРЫН ГАДАРГА, ХЭВЛИЙД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Газрын гадарга бохирдох	Дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө тус үнэлгээний тайлангийн хог хаягдлын хэсэгт заасны дагуу “Хог хаягдлыг дахин ашиглах, зайлуулах, устгах, төлөвлөгөө” боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шаардлагатай. Дулааны станцын талбайн ойролцоо хог хаягдал түр хадгалах цэг байгуулан, хадгалах, төвлөрсөн хогийн цэг рүү тээвэрлүүлэх шаардлагатай.	Төслийн талбай, ажилтнуудын ахуйн байрнаас гарах хог хаягдлыг тухай бүрд нь түр хадгалах саванд хийж тогтсон хугацаанд төв хогийн цэг дээр зориулалтын дагуу хаяж, хогийг ойр орчимд тархахаас сэргийлэн ажилласан. 2023 оны 05 сарын 01-ны өдөр ОНӨТҮГ-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг зориулалтын тээврийнхэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэн хаяж ажилласан.	100%
	Барилгын ажилд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдийг тогтсон нэг зогсоолд байрлуулах, тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоог тогтмол хийж байх, тос масло асгарсан тохиолдолд хамгаалах, саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд автын зогсоол байгуулж, авто хэрэгслүүдийг зогсоолд байршуулж ШТМ асгархаас урьдчилсан сэргийлж ажилласан. Төслийн талбайд авто хэрэгслүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадарга, болон хөрсөн бүрхэвч ШТМ-аар бохирдохоос сэргийлж ажилласан.	100 %
ХОЁР.УУР АМЬСГАЛД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Дулааны станцыг барих, түүхий эдийг зөөвөрлөх үйл ажиллагаанаас тоосжилт үүсч, агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Дулааны станцын барилгын ажлын үед үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замуудад тухай бүр усалгаа хийж байх	Барилгын ажлын үед агаарын чанарт сөргөөр нөлөөлөх нөлөөлөл байхгүй. Барилгын талбайд ажиллаж байгаа машин механизмаас үүсэх тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зориулалтын зам талбайгаар зорчиж байна.	100 %

ГУРАВ. ГАДАРГЫН УСАНД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Тээврийн хэрэгслээс ШТМ асгарах, дулааны станцын яндан, нүүрсний агуулах, үнс хадгалах байгууламжаас үүссэн тоос, дэгдэмхий үнсээр хөрсөн бүрхэвч бохирдож, улмаар хур тунадас орсон үед үерийн усаар дамжин гадаргын усыг бохирдуулж болзошгүй	ШТМ асгарсан тохиолдолд тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал (spill kit)-ыг тээврийн хэрэгслүүдэд болон бусад шаардлагатай газруудад бэлэн байлгах	Барилгын талбайд ШТМ асгарахаас сэргийлж төслийн талбайд техникийн засвар үйлчилгээ хийхгүй байх. ШТМ ашиглахгүй байнгын хяналт тавин ажиллаж байна.	100 %
	Газрын гадарга болон хөрсөн бүрхэвчинд авах арга хэмжээг хэрэгжүүлэх		

ДӨРӨВ. ХӨРСӨН БҮРХЭВЧИД НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хэрэгжилтийн товч тодорхойлолт	Биелэлтийн хувь
Дулааны станц, дулаан дамжуулах шугам болон дулаан дамжуулах төвүүдийг барих явцад нийт 4.51 га талбайгаас нийт 4 тн ялзмагийн нөөц бүхий 9020 м³ үржил шимт хөрс хуулагдаж, эвдэрнэ.	Барилгын ажил эхлэхийн өмнө эвдэгдэх талбайн шимт хөрсийг хуулан авч дулааны станцын эзэмшил газарт шимт хөрсний овоолгын талбайд хадгална.	Дулааны станцын төслийн барилгын ажлуудын явцад барилгын талбайгаас үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.	100 %
ТАВ. АМЬТНЫ АЙМАГТ НӨЛӨӨЛӨХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Барилгажилтын үе: Жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн нүх, оромж нөлөөлөлд өртөж болзошгүй.	Барилгажилтын явцад амьтад устахаас урьдчилан сэргийлж, газар хөндөлтийн өмнө амьтад өртөх эсэхийг шалгах, амьтдыг эрсдэх орчноос үргээж холдуулах,	Дулаан хангамжийг сайжруулах төслийн талбай нь Горхи-Тэрэлжийн шувуудад чухал газар (ШЧГ)-аас 33.7 км, Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсээс 6.4 км, хамгаалалтын бүсээс 8.7 км, онгон бүсээс 11.2 км, аймгийн хамгаалалттай Зуунмод голын орчноос 1.8 км зайд тус тус байрлаж байгаа тул барилгажилт, ашиглалтын үед эдгээр амьдрах орчны биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл байхгүй.	100 %

ЗУРГАА. ФИЗИК БОХИРДОЛ, ДУУ ШУУГИАНААС ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Барилгын ажлын үйл ажиллагаанд ашиглагдах машин техник, тоног төхөөрөмжүүдээс дуу шуугиан үүсч, төслийн ажилчдын эрүүл мэндэд нөлөөлж болзошгүй	Үйл ажиллагааны явцад ашиглагдах техник хэрэгслүүдээс гарах дуу шуугианы түвшинг тухайн техник хэрэгслийн үйлдвэрээс зааж өгсөн дуу шуугианы техникийн үзүүлэлтээс хэтрүүлэхгүй байх,	Барилгын ажилд ашиглаж байгаа техник хэрэгслүүд нь стандарт дуу шуугианы техникийн үзүүлэлтээс хэтрээгүй.	100 %
ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ			
Ахуйн хатуу хог хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан хогийн цэг байгуулан түр хадгалах	Төслийн талбайд ахуйн хог хаягдал хадгалах түр хогийн цэг байгуулан ажиллаж байна.	100 %
БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ			
Харьяа сумын ЗДТГ, БО-ны албанд	Орон нутгийн иргэдийн төлөөлөлийг дулааны станцын талбайд хүлээн авч, Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулах,	Орон нутгийн Байгаль орчин хариуцсан албан хаагчидтай төслийн үйл ажиллагааг танилцуулах цаашид Байгаль орчны чиглэлээр хэрхэн хамтарч ажиллах талаар уулзалт зохион байгуулж ажилласан.	100 %

Газрын гадарга, хэвлийд нөлөөлөх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр

Төслийн талбай, ажилтнуудын ахуйн байрнаас гарах хог хаягдлыг тухай бүрд нь түр хадгалах саванд хийж тогтсон хугацаанд төв хогийн цэг дээр зориулалтын дагуу хаяж, хогийг ойр орчимд тархахаас сэргийлэн ажилласан.

2023 оны 05 сарын 01-ны өдөр ОНӨТҮГ-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг зориулалтын тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт хүргэн хаяж ажилласан.

Төслийн ажлын явцад ахуйн шингэн, хатуу хог хаягдал болон техникийн ШТМ газрын гадаргаас хур тунадасны усаар зөөгдөн гадаргын усыг бохирдуулах сөрөг нөлөөтэй байсан. Тиймээс манай төслийн баг ахуйн хог хаягдлыг дээр дурьдсан шиг түр хогийн цэг байгуулан гэрээний дагуу зориулалтын хогийн цэг рүү зөөвөрлөн асгаж ажилласан.

Төслийн талбайд авто хэрэгсэлүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадаргаар дамжин гадаргын ус ШТМ-аар бохирдохоос сэргийлж ажилласан.

Төслийн талбайд автын зогсоол байгуулж, авто хэрэгсэлүүдийг зогсоолд байршуулж ШТМ асгарахаас урьдчилсан сэргийлж ажилласан. Төслийн талбайд авто хэрэгсэлүүдийн засвар үйлчилгээг хийхийг хориглон зориулалтын засвар үйлчилгээний газарт хийлгэж газрын гадарга, болон хөрсөн бүрхэвч ШТМ-аар бохирдохоос сэргийлж ажилласан.

Төслийн талбай, ахуйн байрны бохир болон шингэн хог хаягдлаар газрын хэвлий бохирдохоос сэргийлэн зориулалтын соруулдаг эко байдлаар хийсэн.



Зураг.1 Ахуйн бохир татан зайлуулж байна.

Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Дулааны станцын төслийн барилгын ажлуудын явцад үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулан авч тусгай овоолгын талбайд хадгалан, нөхөн сэргээлтэд ашиглахаар төлөвлөн ажиллаж байна.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Төсөлд ашиглагдаж байгаа машин техникийн зорчих замын маршрутыг тогтоон өгч заасан маршрутын дагуу замын хөдөлгөөнд оролцуулан тоосжилт үүсж агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг хянаж ажилласан.

Хог хаягдлын менежмент төлөвлөгөөний хүрээнд

Төслийн талбай болон ахуйн байрнаас гарсан хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, шаардлага хангасан түр хадгалах хогийн цэг байгуулан цааш нь нэгдсэн журмаар орон нутгийн төв хогийн цэгт зөөвөрлөн хаяж, хог хаягдлаар хүрээлэн буй орчин бохирдхоос сэргийлэн ажилласан. Хог хаягдлын түр хогийн цэгийн байршлуудыг доор хавсаргав.



Зураг.2 Ахуйн хог хаягдлын түр цэг.

НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Төслийн хувьд барилга угсралтын ажил нийтдээ 25,6 сарын турш үргэлжлэн, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн тул нөхөн сэргээлт, орчны тохижилттой холбоотой ажлуудыг 2024 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгаагүй учраас нөхөн сэргээлт, орчны тохижилтийн ажил 2024 онд хийгдээгүй.

Барилгын ажлын явцад болон дууссаны дараа нөлөөлөлд өртсөн газрыг тэгшилж, дулааны станцын барилга хоорондын талбайг тохижуулах, хөрс хуулалтаас хадгалсан өнгөн хөрсөөр ургамал ургах нөхцөлийг бүрдүүлэх, нөхөн сэргээлт, орчны тохижуулалт болон явган хүний зам, автозамыг хатуу хучилттай болгох ажил хийгдэнэ.

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Судалгааны хүрээнд тус аймагт дулааны станцын төсөлтэй холбоотой нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох айл өрх, хувь хүн, аж ахуйн нэгж байхгүй болно.

Төслийг хэрэгжүүлэх хугацаанд аймаг, сум, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс нүүлгэн шилжүүлэх шаардлага хүргүүлээгүй тул нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа гараагүй.

ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД;

Төв аймгийн Зуунмод хотод баригдах дулааны станцын төслийн үйл ажиллагаанд хамаарах талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар, археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй гэсэн үүрэг хүлээн ажиллаж байна.

ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

Химийн бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөг чиглэлээр

Хүний биед сөргөөр нөлөөлж аюулд хүргэж болзошгүй бодис, хий зэргийг зориулалтын хадгалах саванд хийн анхааруулах тэмдэг байршуулж, шаардлагатай хувцас хамгаалах хэрэгсэлээр ажилтнуудыг бүрэн хангаж ажилласан. Мөн аюултай хортой химийн бодисийн ХАЛМ-ийг ажилтнуудад танилцуулж аюулгүй ажиллагааны талаарх зааварчилгааг өгч ажилласан.



Зураг.3 Химийн хортой бодис болон хийн баллонуудыг зориулалтын хадгалах саванд хадгалсан байдал.

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр

Төсөл эхлэхээс өмнө бүх ажилтнуудад галын аюулгүй байдлын сургалт явуулж баталгаажуулан, төслийн талбай, ахуйн байр, оффис зэрэгт стандарт журмын дагуу галын хоруудыг байршуулан ажилласан. Онцгой байдлын үед төслийн багийнхан цуглах цэгийг тодорхойлж, тэмдэг байршуулсан, төслийн талбай, ахуйн байрнаас гарах бүдүүвч зургийг ажлын талбай бүр дээр байрлуулж өгсөн.



Зураг Галын сарай, галын хор байршуулсан байдал.

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД

“ Энерго Сервис Монтаж ” ХХК-ийн Төв аймгийн Зуунмод хотод хэрэгжүүлж буй дулааны станц барьж ашиглах төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд 2024 оны БОМТ-ний дагуу хөрс, агаар, тоосны, шинжилгээг жилд 1 удаа авч Төв аймгийн УЦУОШ газрын лабораторт, ундны уснаас жил тутам дээж авч итгэмжлэгдсэн лабораторт шинжлүүлж байнгын хяналт тавин ажиллаж байна.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний агро химийн үндсэн үзүүлэлтүүдийг төслийн ажил эхлэхээс өмнө төсөл хэрэгжих талбайгаас 2 цэг сонгон дээж авч итгэмжлэгдсэн лабораторд дээжийг шинжлүүлж дүгнэлт гаргуулж авсан. Үүнд: Хөрсний химийн үндсэн үзүүлэлтүүд, хөрсний механик бүрэлдхүүн, хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн, хөрсний хүнд металлын үзүүлэлтүүд тус тус багтсан.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

10 аймгийн дулааны станц барих төсөл нь нийт 9 аймагт зэрэг хэрэгжиж байна. Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний хүрээнд Эрүүл мэнд, Байгаль орчин аюулгүй байдлыг хариуцсан менежерийн удирдлага доор нийт 9 аймагт гэрээт гүйцэтгэгч 5 компани, туслан гүйцэтгэгч 16 компани ажиллаж байна.

Ерөнхий гүйцэтгэгч “Бьюксан Инженеринг” компанийн зүгээс Эрүүл мэнд, Байгаль орчин, аюулгүй байдлын чиглэлээр холбогдох төрийн байгуулагатай хамтарч ажиллах тал дээр байнгын харилцаа холбоотой ажиллаж байна.

Төслийн хэмжээнд ажиллаж байгаа нийт ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллахаар төлөвлөж байна.

Нийт ажиллагсад болон төслийн талбайд Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдээлэх сургалт явуулж ажиллана.

№	Авах арга хэмжээ	Хугацаа, давтамж	Урьдчилсан зардал, мян.төг	Хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар давтан сургалт, сурталчилгааг хийх	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр	Ерөнхий гүйцэтгэгч Гэрээт компаниуд	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах
2	Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулж ажиллах	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр		Гал түймрийн аюул, эрсдлээс бүрэн сэргийлэх
3	Тухайн орон нутгийн Онцгой байдлын газартай хамтарч ажиллах. Галын аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургалт зохион байгуулж ажиллах	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр		
4	Төслийн хэмжээнд ажиллаж байгаа нийт ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр	Эрүүл мэндийн байгууллага	Ажилчдыг үйлдвэрийн болон бусад гаралтай өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх
5	Ажиллагсдын унд ахуйд хэрэгцээнд ашиглаж байгаа усыг итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэх	Жил бүр	Дотоод төлөвлөлтөөр	Гэрээт компаниуд	
	Дүн		-		

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТАЙЛАН

№	Менежментийн төлөвлөгөөний зардлын агуулга	Зарцуулсан зардлын хэмжээ, мян.төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал	1.253.000
2	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	1.100.000
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	400.000
4	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	
Нийт		2.753.000

ДҮГНЭЛТ

Төв аймгийн төвийн дулаан хангамжийг сайжруулах төсөл эхэлснээс хойш манайх аюул осолгүй, байгаль орчинд ээлтэй ажилласан байна. Энэ хугацаанд байгаль орчны эсрэг гарсан үл тохирол, зөрчилгүй ажилласан.

БОМ-ийн төлөвлөгөө боловсруулж батлуулснаар хүн болон байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг цаг алдалгүй хариу арга хэмжээ авч аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

-Байгаль орчинд сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

-Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон үер усны аюулаас урьдчилан сэргийлэх хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

-Байгаль орчны тухай хууль тогтоомжийг мөрдүүлэн ажиллаж байна.

Бохир ус татан зайлуулах гэрээ



2023 оны 08 сарын 08

Төв Зуунмод

НЭГ ТАЛААС

Монгол Улсын хуулийн этгээд болох Улсын бүртгэлийн 1414001001 тоот дугаартай, регистрийн 3855562 тоот дугаартай Төв Чандмань-ДЭХГ ОНӨААТҮГ-ийн эдийн засагч М.Гангамөрөн

НӨГӨӨ ТАЛААС

Төв Зуунмод сумын 1-р баг Сэрүүн дэнж 11-1 тоот оршин суух НЮ56112817 регистертэй Балдандорж овогтой Нацагням бид нар Монгол улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлийг удирдлага болгон харилцан тохиролцож 2023 оны 08 сарын 08-ний өдөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гүйцэтгэгч тал нь иргэн Б.Нацагням захиалгаар Төв Зуунмод сумын Шинэ Дулааны станцын ажилчдын кемп бохирыг татан зайлуулах ажлыг гүйцэтгэхээр харилцан тохиролцов.
- 1.2 Захиалагч нь ажил гүйцэтгэх гэрээний дагуу гүйцэтгэгчид ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлнө.
- 1.3 Гүйцэтгэгч нь 1.1-д дурдсан ажлыг гэрээнд хоёр тал гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж 2023 оны 08 дугаар сарын 08-ний өдрөөс батлагдсан үнэ өөрчлөгдөх хүртэл хугацаанд байгуулав. Батлагдсан үнэнд өөрчлөлт орсон үед гэрээг тухай бүрд шинэчлэнэ.

ХОЁР. АЖЛЫН ХӨЛС ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1. Энэхүү гэрээний 1 тонн бохир ус зөөвөрлөх ажлын хөлс 21450 /хорин нэгэн мянга дөрвөн зуун тавь/ төгрөг бөгөөд НӨАТ-тай үнэ болно.
- 2.2. Ажлын хөлсийг сар болгоны 25-р тасалбар болгон, гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэлийн ажлын өдөр, тухайн сардаа багтаан дараах дансанд шилжүүлэн төлнө.
Дансны нэр: Тав Чандмань ДЭХГ
Хаан банк: 5721010026, Хас банк: 500202215, Төрийн банк: 310000018516

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Захиалагч нь өөрийн эзэмшлийн бохир усны шугам, худгийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж, стандартын тагтай байлгана.
- 3.2. Бохир ус зөөвөрлөх боломжтой орц, гарцтай байна.
- 3.3. Бохир ус татан зайлуулах хугацаа, хэмжээ болон бусад шаардлагатай мэдээллээр тээвэрлэгчийг хангана.
- 3.4. Захиалагч тал нь гүйцэтгэгч талын ажлыг явуулах хэвийн нөхцөлийг бүрдүүлнэ.

Бохир ус татан зайлуулах гэрээ

- 3.6. Захиалагч нь тээвэрлэлтийн график, давтамж хугацаанд хяналт тавих эрхтэй.
3.7. Захиалагч нь гэрээт ажлын талаар гүйцэтгэгчид санал хүсэлтээ бичгээр илэрхийлж, шаардах зөвлөгөө өгөх эрхтэй.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд заасан хугацаанд заасан бохир ус татан зайлуулах ажлыг урьдчилан мэдэгдсэний дагуу бохирын цооногоос цэвэрлэх байгууламжид хүргэх үүрэгтэй.
4.2. Гүйцэтгэгч нь бохир усыг татан зайлуулах стандартын хэмжээнд цэвэршүүлж байгальд хаях асуудлыг хариуцна.
4.3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд баримтлан ажиллана.
4.4. Тээврийн хэрэгслийг ариун цэвэр, ариутгалын горимыг баримтлан холбогдох байгууллагаар үйлчилгээ хийлгэнэ.
4.5. Гүйцэтгэгч нь уг ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай машин техникийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж ажиллана.
4.6. Гүйцэтгэгч нь машин техник эвдэрсэн тохиолдолд орлох техник хэрэгслээр яаралтай хангана.
4.7. Гүйцэтгэсэн ажил нь шаардлага хангахгүй, дутуу гүйцэтгэсэн нь тогтоогдвол дутуу гүйцэтгэсэн ажлыг захиалагчийн тогтоосон хугацаанд өөрийн зардлаар нөхөн гүйцэтгэх үүрэгтэй.
4.8. Тээврийн хэрэгслийн жолоочийг ажлын хувцсаар хангана.
4.9. Гүйцэтгэсэн ажлын хөлсийг энэ гэрээний 2.1-д заасан дүнгээр тооцон захиалагчаас нэхэмжлэн авах эрхтэй.
4.10. Гүйцэтгэгч нь захиалагч талаас хамааран тогтоосон хугацаанд ажлаа дутуу гүйцэтгэсэн тохиолдолд 4.7 дахь заалт хамаарахгүй бөгөөд энэ талаар захиалагчид даруй мэдэгдэнэ.
4.11. Гүйцэтгэгч тал нь зохих бүх даатгалд хамрагдах шаардлагатай бөгөөд холбогдох зардал нь энэхүү гэрээний үнийн дүнд орсон байна.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
5.2. Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
5.3. Энэхүү гэрээтэй холбоотой аливаа маргаан, санал зөрөлдөөнийг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийг үндэслэн шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагч тал:

төлөөлж
Иргэн
Baldan
Утас: 99302112

Б.Нацагням

Гүйцэтгэгч тал:

Төв Чандмань-ДЭХГ /ОНӨҮГ/-ыг

БОНХАлбаны нягтлан бодогч
Б.Алтантуяа
Утас: 99069556

Эдийн засагч

Утас: 88002841

М. Гангамөрөн

Хог хаягдал тээвэрлэх гэрээ



Зуунмод хот

№

2024 оны 01-р сарын 02-ны өдөр

Монгол Улсын 2017 оны 05-р сарын 12 өдрийн Хот хаягдлын тухай хуулийн/ шинэчлэн найруулсан /10 дугаар зүйлийн 10.1, 10.1.1, 10.2.1, 10.2.2, 10.2.3, 10.2.6, 10.2.7, 10.2.10,10.3.5,10.3.6,14.3.14.2, 41 дугаар зүйлийн 41.1,41.3,41.4,41.5, 43 дугаар зүйлийн 43.1,10.43.1.19 зашгуудыг Зуунмод сум ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 05-р сарын 13-ны өдрийн 05 тоот тогтоолуудын зашгуудыг хэрэгжүүлж ахуйн болон үйлдвэрлэлийн хот хаягдлыг /зөөж тээвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

Энэхүү гэрээг нэг талаас Хот тохижуулах газрыг төлөөлж **Асхах нягтлан бодогч** ажилтай **Бар** овогтой **Мөнхханда**, Нөгөө талаас **Энерго сервис мангяж ХХК төлөөлж Зуунмод Дулааны станиц Төсөл эрхлэсэн захирагч** ажилтай **Балдандорж** овогтой **Нанцгаван** нар харилцан тохиролцож хамтран гэрээ байгуулав.

Нэг: Нийтлэг үндэсэл:

- 1.1. Гэрээний талууд
Ахуйн орчинг цэвэр байлгах, эзэнгүй хог хаягдлыг үүсгэхгүй байх, иргэний үүрээг биелүүлж ахуйн хог хаягдлын тухай хуулийг чандлан мөрдөх чиглэлээр хамтран ажиллана.
- 1.2. Хамтын үйл ажиллагааны санхүүжилтэй холбоотой хөрөнгийн эх үүсвэрийг талууд дараах байлцаар харуулан гаргана. “ Хөрөнгийн төрөл хэмжээ, бэлэн болгох хугацаа зэргийг тодорхой заана”

- А тал
- Б тал

- 1.3. Хамтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой арга хэмжээг талууд дараах байдалаар харуулан зохион байгуулна. “ хийх ажлын чиглэл, төрөл, хийгдэх хугацааг заана.

- А тал
- Б тал

- 1.4. Гэрээний хугацаа **ХОёр** жил байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

Хоёр: Хүлээх үүрэг

- 2.1. **ХТГазар** нь барилгын хог хаягдал авсан төлбөрийг гүйцэтгэлээр нь гүйцэтгэчийн нэхэмжлэлийн дагуу улирал бүрийн **25**-ны дотор хот хаягдлын үйлчилгээний санд төвлөрүүлнэ.
- 2.2. Хот ачих тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангаж, үнс тээвэрдсэн нөхцөлд хучилагаар хангана.
- 2.3. Сар бүр хот хаягдлын төлбөрөө төлсөн газруудын хот хаягдлыг **ДУУДЛАГААР** гаригт ачиж байна.
- 2.4. Хот хаягдлыг захиалагчийн хүсэлтийн дагуу ачиж тээвэрлэж,хог хаях зам тагбай гаргах асуудлыг харуулна.

Гурав: Аж ахуй нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газруудын хүлээх үүрэг

- 3.1. Аж ахуй нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газрын хог хаягдал нь хүн амьтан болон ахуйн орчинд хор хөнөөл учруулахааргүй байна.
- 3.2. Албан байгууллага, аж ахуй нэгж, үйлдвэрийн газрууд нь сард 1 удаа өөрсдийнхөө харьяа газар болон хашаныхаа гадна талын 50 м хүртэлх газрын хогийг цэвэрлэж байх.
- 3.3. Хог хаягдлын дотор тэсэрч дэлбэрэх хэлбэрийн зүйлс байхгүй байх,хэрэв тэсэрч дэлбэрч болзошгүй эд зүйлс байвал дээд шатны албан тушаалтанд мэдэгдэж зөвшөөрөл өгсөн тохиолдолд ачилт хийж байна.
- 3.4. Хог хаягдлын төлбөрийг сар бүр гэрээнд тусгасан үнэлгээний дагуу төлсөн байх.
- 3.5. Аж ахуй нэгж албан байгууллага хуулийн дагуу зориулалтын байгууллагаар үйлчилүүлэх.

Дөрөв: Хамтран хүлээх үүрэг

- 4.1. Уг гэрээ нь 2 тал харилцан тохиролцож гарын үсэг зурж Хог тохижуулах газрын даргаар батлуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Гэрээнд хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас учирсан хохирлыг аль буруутай тал зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 4.3. Гэрээний заалтанд маргаан гарсан тохиолдолд 2 тал харилцан тохиролцож ярилцсаны үйлсэн дээр зөв шийдвэр гаргаж нэмэлт өөрчлөлт оруулах буюу цуцлана.

Гэрээнд орсон нэмэлт өөрчлөлт:

Хог хаягдлыг битүүмжлэсэн тусгай зориулалтын автомашинаар өчинг.
Банкны нэр – Төрийн сан
Дансны дугаар-100142200947
Байгууллагын нэр- Тө.Хог хаягдлын хураамжс орлого
Регистрийн дугаар-9069011
Сарын төлбөр-100,000.00

Гэрээ байгуулсан:

Хог тохижуулах газрыг төлөөлж
Ахлах нягтлан бодогч
Хот тохижуулах газрыг төлөөлж
Байгууллагыг төлөөлж:
Зууныод тээвэрлэх станц
Төсөн хэрэгцээг захирагч
Бидэнд орлогч инженер
Байдал: 520302.03.8
20...01...сарын...өдөр

Утас:70272562

Утас: 99302112

Агаарын шинжилгээний хариу

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/54
дүгээр тушаалын 02 дугаар хавсралт
Маягт 7.8.1



ТӨВ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Төв аймаг, Зуунмод сум 6-р баг
Утас 70273864, 88307506
E-mail



СОРИЛЫН ТАЙЛАН

Дугаар он, сорьцын бүртгэлийн код №	2024.07
Сорьц ирүүлсэн байгууллагын нэр, хаяг	"Энергосервисмонтаж" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	Ч.Саранхүү Лабораторийн агаарын техникч
Сорьц авсан аймаг, сум, газрын нэр	Төв аймаг Зуунмод сум " Дулааны станц
Сорьцын төрөл, хэмжээ, тоо	Агаар, 1 дээж
Сорьц авсан огноо	2024.07.19
Лабораторид ирсэн огноо	2024.07.19
Шинжилгээ хийсэн огноо	2024.08.16
Хуудасны тоо	1
Хэвлэсэн огноо	2024.08.18

Агаарын шинжилгээний дүн

№	Шинжилсэн үзүүлэлт	Шинжилсэн аргын стандарт MNS	Стандарт хэмжээ (мг/м³)	Сорьц -1
1	Хүхэрлэг хий /SO2/	MNS 0017-2-12:2021	0.450 мг/м³	0.010
2	Азотын давхар исэл /NO2/	MNS 0017-2-511:2021	0.200 мг/м³	0.013

Шинжилгээний дүнг агаарын чанарын MNS 4585:2016 стандарттай харьцуулан гаргахад стандарт хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна.

Шинжилгээ гүйцэтгэсэн:

Агаарын ахлах техникч ... /Ч. Саранхүү / Ч. Саранхүү /
(гарын үсэг) (нэр)

Хянасан :Лабораторийн эрхлэгч /Оронбат /
(гарын үсэг) (нэр)



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Хөрсний шинжилгээний хариу

Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/54
дүгээр тушаалын 02 дугаар хавсралт
Маягт 7.8.1



ТӨВ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

Төв аймаг, Зуунмод сум 6-р баг
Утас 70273864, 88307506
E-mail



СОРИЛЫН ТАЙЛАН

Дугаар он, сорьцын бүртгэлийн код №
Сорьц ирүүлсэн байгууллагын нэр, хаяг
Сорьц авсан хүний нэр, албан тушаал
Сорьц авсан аймаг, сум, газрын нэр
Сорьцын төрөл, хэмжээ, тоо
Сорьц авсан огноо
Лабораторид ирсэн огноо
Шинжилгээ хийсэн огноо
Хуудасны тоо
Хэвлэсэн огноо

2024.07.08
"Энергосервисмонтаж" ХХК
Н.Оронбат Лабораторийн ерөнхий инженер
Төв аймаг Зуунмод сум " Дулааны станц "
Хөрс, тус бүр 0.5 гр 2 дээж
2024.07.19
2024.07.19
2024.08.16
1
2024.08.18

Хөрсний шинжилгээний дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	Чийг %	РН	Ялзмаг	NH ₄ мг/кг	NO ₃ мг/кг	PO ₄ мг/кг	SO ₄ мг/кг
1	СОРЬЦ-1/шимт хөрсний овоолго/	5.15	8.04	0.10	35.63	14.21	11.33	20.5
2	СОРЬЦ-2/хөрс/	6.77	7.98	0.21	43.26	13.77	8.62	65.2
Шинжилсэн аргын стандарт MNS		MNS 3310:1991						

Шинжилгээ гүйцэтгэсэн:
Инженер...*Б.Бумдарь*.../ Б.Бумдарь /
(гарын үсэг) (нэр)

Хянасан : Лабораторийн эрхлэгч...*Н.Оронбат*.../ Н.Оронбат /
(гарын үсэг) (нэр)



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хамаарна.

Усны шинжилгээний хариу



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний лавлагаа лабораторийн
Ерөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ
Төв аймаг Зуунмод сум, Номт 1-р баг.
Утас: 70273610, Факс: 70273913

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар /Registration number/: 24-215

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : ЭНЕРГО СЕРВИС МОНТАЖ ХХК
/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/: Эрүүл ахуйн, хими хор судлалын
лаборатори; Эрүүл ахуйн нян судлалын лаборатори;

Дээжийн тодорхойлолт /Sample description/					
Дээжийн дугаар Sample number	Дээжийн нэр Name of sample	Цувралын дугаар Batch number	Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry	Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample
641	Ундны ус	Тодорхойгүй	Монгол Улс	Тодорхойгүй	2500 мл

Хүлээн авсан огноо Date of receipt	Шинжилгээ дууссан огноо Date of test completion	Хэвлэсэн огноо Date of issue of the report
2024 он 03 сар 25 өдөр	2024 он 03 сар 28 өдөр	2024 он 03 сар 28 өдөр

Дээжийн дугаар Sample number	Шинжилгээний аргын стандарт Method of analysis	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit	Шаардлага Test specification, unit	Шинжилгээний дүн Test results
641	MNS ISO 6059:2005	Кальци	100мг/л	43.2мг/л
	MNS ISO 6059:2005	Магни	30мг/л	18.4мг/л
	MNS 4430:2005	Нийт төмөр	0.3мг/л	0.1мг/л
	MNS ISO 7890-3:2001	Нитрат	50мг/л	14мг/л
	MNS 4431:2005	Нитрит	1мг/л	0мг/л
	MNS ISO 10523:2001	РН	6.5-8.5	7.67
	MNS 6271:2011	Сульфат	500мг/л	33.5мг/л
	MNS 6272:2011	Фтор	0.7-1.5мг/л	0.1мг/л
	MNS ISO 6059:2005	Хатуулаг	7.0мг-экв/л	3.9мг-экв/л
	MNS 4423:1997	Хуурай үлдэгдэл	1000мг/л	322мг/л
	MNS ISO 7888:1999	Цахилгаан дамжуулах чанар	1мСм/см	0.04мСм/см
	MNS 4424:2005	Хлорид	350мг/л	18.5мг/л
	MNS ISO 6222:1998	ББЕТ	1мл-т 100аас бага	62ш
	MNS ISO 19250:2017	Гэдэсний бүлгийн нян	25 мл-т илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100мл-т илрэхгүй	Илрээгүй

Санал тайлбар:

Opinions and interpretation

БАТАЛСАН:ЛАБОРАТОРИЙН
Approved by ЭРХЛЭГЧ



/Б.ХИШИГТОГТОХ/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна.
Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.